

ХОРЕЗМЫН АЯН ДАЙНЫ СУРАГ ЧИМЭЭ ӨРНӨД ЕВРОПТ СОНСОГДСОН НЬ

*Л.Оюунгэрэл**

Чингис хаан элчүүдийг нь зэрлэгээр хороосон Хорезмын шахын эсрэг 1219 оны 9 сард анх цэрэг хөдөлгөсөн нь Дорно зүгт лалын хүчирхэг ертөнцийн бэлэг тэмдэг болсон Хорезмыг сөнөөх, Евразийн өргөн уудам нутгийг байлдан дагуулах, улмаар дэлхийн түүхэнд нөлөө үзүүлэх аян дайн болсон билээ.

Монголчууд Өрнө, Дорнын уулзвар болсон энэхүү бүс нутагт нэвтэрч, 1222-1224 онд Кавказ, Зүүн-Өмнөд Европын улс орнуудыг тандан судалж түрэмгийлэн эзэлж Евразийн өргөн уудам нутагт хяналтаа тогтоов. Чингис хааны аян дайны цуурай бүс нутагтаа төдийгүй алс холын Өрнөдийн орнуудад ч дуулджээ. 1221 оны 4 сарын 18-нд Жак де Витри хэмээх Палестины Акка хотын хамба Ромын пап Хонорьус III, Австрийн ван Леопольд, Английн хаан Хенри III, Парисын Их сургуульд нэгэн сонирхолтой захидал илгээжээ. Тэр захидалд: “Дэвид хэмээх Энэтхэгийн хаан Христийн хүчирхэг хамгаалагч үй олон цэрэгтэй буруу номтныг дарахаар айсуу. Тэрээр Хорезмын хааныг унагаж Персийг бараг эзэлж одоо Багдад, Мосул хотоос тав хоногийн зайд байлдаж байна” гэжээ.¹ Бас Л.Н.Гумилевын олж уншсанаар “Дэвид хааны цэрэг Антиохоос 15 хоногийн зайд байлдаж байна. Христийнхэнд туслахаар айсуу” гэжээ.² Харин В.В.Бартольд арабын түүхч Ибн Ал Асираас иш татан: “Багдадын халиф тус хотын нестор хамбатай зөвлөлдөж Дэвид хаанд элч илгээсэн ба тэдгээр элч нарын нөлөөн дор Дэвид хаан Хорезмын эсрэг дайн эхэлсэн” гэжээ. Тэр хаан бол “Кучлук юм” гэж Бартольд тайлбарласан байдаг.³ Хорезмын шах 1217 онд Персэд эрх мэдлээ дахин тогтоосон байсан ч тэр жилийнхээ өвөл Хамаданы ойролцоо түүний цэргүүд бутцохигдоод байсан тухай Ибн Ал Асир бичжээ. Жак де Витри захидалд бичсэн мэдээллээ лалынханд олзлогдсон загалмайтны цэргүүдээс авсан ба тэднийг “Дэвид хааны цэргүүд христийнхэн гэж мэдээд чөлөөлж Антиох руу буцаасан” гэж 1723 онд Парис хотод загалмайтны аян дайны тухай сударт өгүүлсэнийг Р.Хенниг ба бусад олон эрдэмтэн иш татдаг ажээ. Харин Л.Н.Гумилев Дэвид хаан гэж Кучлукийг хэлсэн ба харин Кучлук тэр үед аль хэдийн бурхан болсон байсан; гэтэл Европынхон тусламж ирнэ гэж горьдсоор байсан⁴ гэсэн нь хэрэг дээрээ В.Бартольдын дүгнэлтийг давтсан ажээ. Гэтэл 1217 ба 1221 оны 4 сар гээд бүтэн дөрвөн жилийн зөрүүтэй болсон үйл явдлуудын тухай энд ярьжээ. Энэ захидалд тоомжиргүй хандах хандлага түүхчдийн дунд давамгайлдаг учраас үүнийг арай илүү нухацтай авч үзэхийг оролдоё.

*Л.Оюунгэрэл - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор (Ph.D)

Загалмайтнууд монголчуудын тухай хэдийнээс мэдэх болсон? Тэд дээрх захидалд бичсэн шиг монголчуудыг “христийнхэнийг чөлөөлөхөөр айсуй” гэж итгэж горьдох бодит нөхцөл байсан эсэхийг тодруулахыг оролдоё. 1220-1221 онд Өрнөд Ази ба Төв Азид дэлхийн түүхэнд гүнзгий ул мөрөө үлдээх учиртай хоёр том тулалдаан болж байв.

1095 онд анх эхэлж 100 гаруй жил үргэлжилсэн христийнхэн ба лалынхны хоорондын дайн дахин эрч хүчээ авч, 1217 онд эхэлсэн загалмайтны V дайн эхэлсэн ба Өрнөд Европоос Герман, Дани, Норвег зэрэг улсын загалмайтны цэрэг Сирид цуглаж Египетийн эсрэг дайрахаар бэлдэж байв. Унгарын хаан, Австрийн ван Леопольд Европуу буцсан ба Францын цэргүүд 1217 оноос Нил мөрний эрэг дээр орших Дамизтта боомтыг 18 сарын турш бүслэн хааж 1219 онд эзэлж авчээ. Энэхүү тулалдааны тухай Рашид-Ад Дин “Судрын чуулган” номондоо дэлгэрэнгүй бичсэн байдаг. Харин 1221 оны хавар тэд ухарч Каирын аян дайн сүйрэлд ороод байв. Чухам энэ үед Де Витри гэгч дээрх захидлаа бичсэн ажээ.

Тэгвэл 1221 оны хавар Чингис хаан ба түүний цэргүүд чухам хаана байлдаж байв? 1221 онд Чингис хааны байлдаж явсан газрыг мөшгин судлахад доорх чиглэлүүд тодорч байна.

Чингис хаан 1220-1221 оны өвөл Сали Сарай-д Карши-д өвөлжөөд улмаар 1221 оны 1 сард Гурганж-д, 4 сард Балх хотод, улмаар Таликан, ба Таликаны ойролцоох Нусрет-Кух хэрмийг эзлэхийн төлөө тулалдаж байв. Тэгвэл 1221 оны 1-5 сард Витригийн захидалд дурьдагдсан Багдад ба Мосул хотод хамгийн ойр байршилтай газар жанжнуудаас нь хэн тулалдаж байв? гэсэн асуулт гарна. Хорезмын Шах Мухаммедыг мөшгин хөөсөн тус бүр нэг түмэн цэрэгтэй Сүбээдэй, Зэв, Тогучар нар Завах, Нишапур, одоогийн Тегераны ойролцоо Рэй хотуудад дайралт хийж, улмаар 1221 оны 2 сард Азербайжан, Гүрж, Курдистаны нутагт байлдаж байжээ. Харин Желал-Ад-Диныг мөшгөн хөөсөн Тулуйн цэрэг Мерв хотод 1221 оны 2 сарын 25-нд орж, улмаар Мургаб, Нишапур хотыг 1221 оны 4 сарын 10-нд бүрмөсөн эзэлж авчээ.

1221 онд загалмайтны байлдаж байсан Сири улсад Чингис хаан, монголчуудын Хорезмын аян дайны талаар тун сайн мэдээлэлтэй байсныг XIII зууны сирийн түүхч Абу-л-Фарадж-бар-Эбрейн судар гэрчилж байна. “Дэлхийн түүх” номондоо тэрээр Зэв, Сүбээдэй нарын Иран руу хийсэн анхны довтолгооны талаар бичихдээ: “Тэр жил тайайе (арабууд)-чуудад Өрнө зүгээс ирсэн франкуудын (загалмайтны цэргүүд) зүгээс төдийгүй гол нь Дорно зүгээс асар хурдацтай довтолж Хамадан, Азербайджан, Араныг хүрсэн татарууд (tataraje) аюул учруулахаар байв. Перс орон тэг чигээрээ айдас хүйдэст автагдав” гэжээ.⁵

Дээрх баримтуудаас харахад де Витри бодит баримт дээр тулгуурлан захидлаа бичсэн төдийгүй Монголын аюулын талаар Өрнөдөд анх мэдээлсэн хүн ажээ.

Загалмайтны цэргүүд Төв Азиас гаралтай нүүдэлчдийг байлдах урлагт сайн гэдгийг эртнээс мэддэг байжээ. Франкууд, жишээлбэл бүр Загалмайтны IV аян дайны үеэр 1206 онд Булгарын хааны талд байлдаж байсан монгол гаралтай гэх кипчакуудтай тулгарч байв. Энэхүү аян дайнд оролцсон франк язгууртан Жоффрэ де Вильардуэн (Geoffroy de Villehardouin) загалмайн дайны тухай тэмдэглэлдээ: “Команы (кипчак) удирдагч Коркас байлдааныг хошуучилж 1206 оны 1 сарын 31-нд болсон энэхүү тулалдаанаар Фландрын Балдуиныг (Baudouin) амьдаар нь барьж гүн Луи байлдааны талбарт алуулсан” гэжээ.⁶ Тэгвэл Л.Гумилев энэ тулалдааны тухай бичихдээ “Балдуин 1204 онд Константинополийн эзэн хаан болоод байв” гээд “загалмайтнууд 1207 онд Булгарын хаантай найрамдлын гэрээ байгуулснаар өөрсдийгөө аварсан юм” гэжээ.⁷ Үүнээс харахад Булгарын хаанд зүтгэж байсан кипчакуудын тусламжтай дайны явцад шийдвэрлэх ялалт байгуулсан байжээ. Үүнээс юу гэж дүгнэж болох вэ? гэвэл загалмайтнууд тэр үед монголчуудыг яг тухайлж мэдэхгүй байсан ч Дорнод Азиас гаралтай нүүдэлчдийн байлдааны ур чадварыг өндөр үнэлдэг байсан бололтой. Дээр бидний иш татсан франк загалмайтны тэмдэглэлд “комануудын морин цэрэг байрлалаа маш түргэн сольж байлдаж” байсан тухай бахархан бичсэн байдаг.

ИШЛЭЛ

1. M.Prawdin, The Mongol Empire its rise and legacy, London, 1940, p.14
2. Л.Н.Гумилев, В поисках вымышленного царства, М, 1992, с. 136
3. В.Бартольд, Туркестан под владычеством монголов (1227-1269), Сочинения, том 1, М, 1963, с. 440
4. Л.Н.Гумилев, В поисках вымышленного царства, М, 1992, с. 135
5. Р.Гусейнов, Сирийские источники XII -XIII вв. об Азербайджане, Баку, 1960, с.75
6. Denis Sinor, Quelques passages relatifs aux comans, tires des chroniques francaises de l'epoque des croisades, in: Silver Jubilee volume of the Zinbun Kagaku Kenkyusyo Kyoto University, 1954, pp. 374-375
7. Л.Н.Гумилев, В поисках вымышленного царства, М, 1992, с. 138